

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

“Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн заалтууд, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугар тогтоол болон 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн тогтоол №45 батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам” болон холбогдох хууль тогтоомжийн дагуу 2021 оны 4-р сарын 30-ны өдрийн 15:00 цагаас “Zoom” програм ашиглан цахим хэлбэрээр хийлээ.

Хурлын дарга О.Эрдэнэбулган: “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн цахим хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. 2021 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг компанийн тухай хуульд нийцүүлэн гаргасан байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлөөс намайг хурлыг удирдуулахаар томилсон. Тус хурал нь цахим хэлбэрээр явагдаж байгаа онцлогтой учраас урьдчилан ирүүлсэн “Саналын хуудас”-нуудыг хэвлэж санал хураах хайрцагт хадгалсан байгаа. Хуралд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, тус хурлын зохион байгуулах комиссын дарга А.Санчирмаа, “Гендекс” ҮЦК-ийн Ч.Бат-Өлзий, Д.Дэлгэрмаа нар, “Монгол Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Л.Таня, “Би Ди Сек” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Өлзиймаа, хувьцаа эзэмшигч Э.Золзаяа, Хууль эрх зүйн албаны дарга Т.Наранцогт, компанийн зөвлөх Б.Аюуш нар цахимаар хуралд оролцож байна. Санал хураах хайрцагийг нээж байж хурлын ирцийг тогтоох болно. Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдэд харуулан лацадсан дугтууг нээнэ үү.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий санал хураах хавтасын битүүмжлэлийг задалж, 3 саналын хуудас гаргав.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий: “Монгол Даатгал” ХК нь нийт 64,132,341 ширхэг хувьцаатай, үүнээс 109,239 ширхэг халаасны хувьцаатай буюу саналын эрхтэй 64,023,102 ширхэг хувьцаатай, саналын хайрцагнаас нийт 3 саналын хуудас гарлаа. Нийт 267 хувьцаа эзэмшигч байгаа. “Миллениум Секьюритис Менежмент Лимитед” компани 63,997,215 ширхэг хувьцаатай, Э.Золзаяа 154 ширхэг хувьцаатай, “Би Ди Сек” ХХК 97 ширхэг хувьцаатай байна. Нийт саналын эрхтэй 63,997,466 ширхэг хувьцаатай буюу 99,8 хувийн ирцтэй байна. “Компанийн тухай хууль”-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай Тооллогын комиссын анхдугаар тогтоолыг танилцуулья.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий тооллогын комиссын тогтоол №01-ийг уншиж танилцуулав.

Хурлын дарга О.Эрдэнэбулган: Хурлын ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцох ирц хүрсэн учраас хурлаа нээж, Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн тогтоолыг болон уг тогтоолоор баталсан хурлыг дэгийг танилцуулья.

ТУЗ-ийн тогтоолыг бүтнээр нь уншиж танилцуулав.

Хурлын дарга О.Эрдэнэбулган: Хурлаар хэлэлцэх асуудлуудын материалыг та бүхэнд хүргүүлсэн. Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудал бол "Монгол Даатгал" ХК-ийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах юм. Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг товч танилцуулья.

2020 оны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн товч презентаци танилцуулав.

ТУЗ-ийн гишүүн Л.Таня: ТУЗ-ийн дүгнэлтийн тогтоолыг танилцуулья.

ТУЗ-ийн компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг танилцуулав.

ТУЗ-ийн гишүүн Л.Таня: Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус дүгнэлтийг гаргасан бөгөөд хувьцаа эзэмшигч та бүхэн баталж өгнө үү.

Хурлын дарга О.Эрдэнэбулган: ТУЗ-ийн гишүүн Л.Таня танд баярлалаа! Дараагийн асуудлыг хэлэлцэхээс өмнө та бүхэнд жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангаа товч танилцуулахдаа нэг зүйлийг танилцуулахаа орхигдуулсан байна. Энэ нь ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулья.

2021 оны 02-р сарын 19-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн "Ногдол ашиг хуваарилах эсэх тухай" №21/03 тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга О.Эрдэнэбулган: Тус шийдвэрийн дугаар 2-т 2021 оны 04 дүгээр сард хуралдах хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шалтгааныг тайлбарлахыг надад үүрэг болгосон. Ногдол ашиг хуваарилахгүй гол шалтгаан бол та бүхэн саяхан компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийг харсан байх борлуулалтын хураамжийн орлого 29 хувиар буурсан, үүнтэй холбоотойгоор мөн цар тахал зэргээс хамаарч ногдол ашиг хуваарилах боломж бидэнд байсангүй. Цар тахал, эдийн засгийн нөхцөл байдал мөн 2020 оны компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийг харгалзан үзэж тус дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргасан. 2021 онд хөл хорионы үеэр ажилтнуудынхаа цалинг тасралтгүй олгох, гүйцэтгэлээр нь олгох мөн ажлаа хийх боломжгүй ажилтнуудад 50, 60 хувиар, цалингийн доод хэмжээгээр цалин олгох зохицуулалтаар ажиллаж байна. Компанийн 6 сарын санхүүгийн нөөц, компанийнхаа тогтмол зардлуудыг гаргаж чадахуйц мөнгөн хөрөнгийн сантай, хувьсах зардлуудаа танах дээр арга хэмжээ авч ажиллаж байна. Ийм үүднээс компанийн ногдол ашиг таарахгүй гэсэн шийдвэр гарсан. Тус шийдвэр мөн Монголын Хөрөнгийн биржийн сайт дээр байршуулсан, Санхүүгийн зохицуулах хороонд мөн хүргүүлсэн.

Хурлын дарга О.Эрдэнэбулган: Дараагийн хэлэлцэх асуудал бол 2021 оны ТУЗ-ийн зардлын төсвийг хэлэлцэх ёстой. Та бүхэнд дэлгэц дээр харуулж байна.

Хурлын дарга О.Эрдэнэбулган: Хурлын дэгийн дагуу та бүхэнд хэлэлцэж буй асуудлуудтай холбогдсон асуулт байна уу?
Хуралд оролцогчдоос асуулт гарсангүй.

Хурлын дарга О.Эрдэнэбулган: Та бүхэнд Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төслүүдийг танилцуулья.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр №01 болон шийдвэр №02-ийг уншиж танилцуулав.



Хурлын дарга О.Эрдэнэбулган: Та бүхэнд хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт байна уу?

Хуралд оролцогчдоос асуулт гарсангүй.

Хурлын дарга О.Эрдэнэбулган: Хуралд оролцогчдоос асуулт гараагүй учир хурлаа үргэлжлүүлэн тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий санал тоолох ажилд зориулан цаг өгөх үү?

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий: Саналын тоолох ажил дууслаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын дүн дараах байдалтай байна. Нийт 63,997,466 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид саналаа өгч хэлэлцсэн бүх асуудлаар 100 хувийн саналаар зөвшөөрсөн байна. Татгалзсан санал байхгүй тул баталсанд тооцов.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий тооллогын комиссын тогтоол №02-ийг уншиж танилцуулав.

Хурлын дарга О.Эрдэнэбулган: Тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа. Үүнийг үндэслэж хурлаас гарах шийдвэрүүдийг танилцуулья. Компанийн тухай хуулийн 62.1.9, 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын №02 тогтоолыг үндэслэн тогтоох нь:

Нэгдүгээр асуудлаар: "Монгол Даатгал" ХК-ийн 2020 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хоёрдугаар асуудлаар: ТУЗ-ийн 2021 оны төсвийг хавсралтаар баталсугай. Батлагдсан төсвийг мөрдөн, ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллахыг ТУЗ /Громов С.Б./-д үүрэг болгосугай

Дээрх 2 тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан болохыг та бүхэнд мэдэгдлээ. Хуралтай холбоотой сайжруулах, анхаарах зүйлс байвал хувьцаа эзэмшигчдийн хурлын комиссын дарга А.Санчирмаа, хурлын дарга О.Эрдэнэбулган миний биед компанийн вэбсайтаар дамжуулан саналаа илгээж, мэдээлэл авахад нээлттэй юм шүү. Хувьцаа эзэмшигч та бүхэн компанидаа итгэх итгэлээ хадгалж, хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцож байгаад талархснаа илэрхийлье. Та бүхэн халдвар хамгааллын дэглэмээ сайн сахиж, эрүүл байж, COVID-гүй цаг үе хурдан ирэх болтугай гэж ерөөе. Өнөөдрийн хурал хаасныг мэдэгдье.

Хурал 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 16:00 цагт өндөрлөв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: *А. Санчирмаа* А.Санчирмаа

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА: *О.Эрдэнэбулган* О.Эрдэнэбулган